

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН  
ТАЛААРХ ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 05 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ИЛТГЭГЧ нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бурдсэн Үндэсний зөвлөл мэдээллийн технологийн компаниудыг тодорхой шалгуураар виртуал бүсэд буюу цахим орчинд бүртгэх, тэдгээрт татварын болон татварын бус дэмжлэгээр зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан. Цаашид татварын болон татварын бус хөнгөлөлтөд тавигдах шалгуурыг төсвийн хуультай уялдуулах, виртуал бүсэд ажиллах журамд Засгийн газар шалгуурыг тодорхой тусгаж өгөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Хуулийн төсөлд тусгагдсан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан хуулийн цоорхой үүсэхээс сэргийлэх талаар нарийвчилсан зохицуулалтын журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам Сангийн яам хамтран боловсруулах талаар тус тус санал хэлсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац,

цахим бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг  
Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

